



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу-15, Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809
E-mail: contact@ub-procurement.mn
http://www.ub-procurement.mn

2017.12.19

№

01/1961

танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТЭСТ**

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу Байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 37 хуудастай.

ДАРГА



Э.БОЛОРМАА



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН БОДЛОГО ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Чанартай худалдан авалтыг хуулийн хүрээнд, олон нийтийн оролцоотойгоор, баялаг бүтээгчдийг тэгш өрсөлдүүлэх зарчмаар, ил тод орчинд, үр ашигтай зохион байгуулж Нийслэл хотын бүтээн байгуулалтад манлайлан оролцогч мэргэшсэн байгууллага байна.

Газар нь эрхэм зорилго, стратегийн зорилтын хүрээнд Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2017 оны зорилтод тусгагдсан арга хэмжээг үйл ажиллагаандаа уялдуулан ажиллав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”:

1.1 Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, үр дүн

“Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах”.

а/ Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

- 2017 онд худалдан авах ажиллагааны олон улсын журмаар Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй 15 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна.
- Худалдан авах ажиллагааг олон улсын журмаар зохион байгуулахад хамтран ажиллаж буй донор байгууллагаас зохион байгуулсан дараах 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 12 албан хаагчийг хамруулж, туршлага солилцон ажиллаж байна.

б/ Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

- Монгол улсын Сангийн яамны 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан. Үүнтэй холбоотой тус газрын Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтэс, Хууль, хяналтын хэлтсээс “Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын эрх, үүрэг”-ийг хуульчлах талаарх шаардлага, үндэслэлийг боловсруулж, 2017 оны 06 сарын 13-ны өдөр ажлын хэсэгт танилцуулсан.
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын албан хаагчид болон тендерт оролцогч аж ахуйн

нэгжүүдийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Уг хэлэлцүүлэг нь тус байгууллагын болон Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах мэргэжилтнүүдийг хамруулан 2017.09.05-ны өдөр, тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийг хамруулан 2017.09.06-ны өдөр тус тус зохион байгуулагдсан.

- Тус газрын дарга Э.Болормаа нь Нийслэлийн Засаг даргын А/605 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, тендерийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, авлигаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээллийг газар зүйн мэдээллийн системд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн сан үүсгэх, Шилэн тендерийн журмын төсөл боловсруулахад хамтран ажиллаж байна. Мөн тус газрын 2017 оны 09 сарын 08-ны өдрийн А/121 тушаалаар саналболовсруулах ажлын хэсгийг байгуулсан ба улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээллийг газар зүйн мэдээллийн системд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд оруулах саналыг Нийслэлийн Засаг даргын А/605 дугаар захирамжаар батлагдсан журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлээд байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендерийн жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 02/1758 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг 2017 оны 11 сарын 11-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн.

в/ Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах:

- Төрийн цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn-д 2017 оноос эхлэн Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улсын төсвийн 15,520.4 сая төгрөгийн 67, нийслэлийн төсвийн 395,776.2 сая төгрөгийн 661 төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн www.tender.gov.mn цахим системд төлөвлөх, Монгол улсын Сангийн яамаар батлуулах, Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн систем дэх эрх шилжүүлэлтийг хийх мөн Дүүргийн Засаг дарга нараас эрх шилжүүлсэн 24,373.8 сая төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолд үндэслэн цахим системд төлөвлөх, Төсвийн Ерөнхийлөн захирагчаас батлах ажлыг www.tender.gov.mn цахим системээр дамжуулан хийж гүйцэтгэж байна. Мөн системд заасан маягтын дагуу төсвийн тодотгол, өөрчлөлт болон төсөл, арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа Монгол улсын Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөний өөрчлөлтийг батлуулж, нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалт худалдан авалтыг уг системээр дамжуулан зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Үүнд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн

батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас батласан “Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-г 2017.01.15 өдрийн дотор уг системд нийтлэж, олон нийтэд зарласан. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусган Монгол улсын Сангийн ямаар батлуулж, захирамжийн дагуу эрх шилжүүлж ажилласан.

- Сангийн яамны Хууль Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран 2017.03.31 өдөр “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалт зохион байгуулж, 9 Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 19 мэргэжилтэнд худалдан авах ажиллагааны хэтийн чиг хандлага, цахим системийн онцлог давуу талын тухай мэдээлэл өгч ажилласан.
- Хууль, журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллага хоорондын уялдааг сайжруулах зорилгоор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга нартай хийх уулзалтын удирдамжийг 2017 оны 02 сарын 23-ны өдөр батласан. Үүний дагуу 2017 оны 03 сарын 14-ний өдрийн 09-12 цагийн хооронд уулзалт зохион байгуулж, 9 Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах мэргэжилтэн 14 албан хаагчид худалдан авах ажиллагааг зохион байгуулахад гарч буй хүндрэлийн талаар санал солилцон, цаашид худалдан авах ажиллагааг ил тод, шуурхай, богино хугацаанд зохион байгуулахад анхаарах асуудлаар зөвлөмж, чиглэл өгч ажилласан.
- Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, захирамж гаргасантай холбоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтын дагуу Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг www.tender.gov.mn, <http://tender.ub-procurement.mn/> -д ил тод, нээлттэй мэдээлэх, биелэлтийг тайлагнах талаар 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад зөвлөмж чиглэл хүргүүлсэн.
- Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг

хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.

- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран 2017 оны 12 сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.
- Тус газарт Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn системээр 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, тендертэй холбоотой бүх төрлийн баримт бичгийг /файлаар/ нийтэлж, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.
- Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендер зарлагдсан 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний урилга, зар болон сонгон шалгаруулалтын дүн гарсан 152,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 327 төсөл, арга хэмжээтэй холбоотой шалгарсан, шалгараагүй талаарх мэдээллийг оролцогч тус бүрээр зарлан мэдээлээд байна.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлж, баяжуулах”

а/ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Төрийн өмчийн хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил үйлчилгээний худалдан авалтаар ерөнхий гэрээ байгуулах” журам батлагдаж гараагүй байна.

1.2 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, үр дүн

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

1.3 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын биелэлт, үр дүн

Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулна.

a/ Худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгох чиглэлээр:

- Төрийн цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn-д 2017 оноос эхлэн Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улсын төсвийн 15,520.4 сая төгрөгийн 67, нийслэлийн төсвийн 395,776.2 сая төгрөгийн 661 төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн www.tender.gov.mn цахим системд төлөвлөх, Монгол улсын Сангийн ямаар батлуулах, Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн систем дэх эрх шилжүүлэлтийг хийх мөн Дүүргийн Засаг дарга нараас эрх шилжүүлсэн 24,373.8 сая төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолд үндэслэн цахим системд төлөвлөх, Төсвийн Ерөнхийлөн захирагчаас батлах ажлыг www.tender.gov.mn цахим системээр дамжуулан хийж гүйцэтгэж байна. Мөн системд заасан маягтын дагуу төсвийн тодотгол, өөрчлөлт болон төсөл, арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа Монгол улсын Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөний өөрчлөлтийг батлуулж, нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалт худалдан авалтыг уг системээр дамжуулан зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Үүнд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас батласан “Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-г 2017.01.15 өдрийн дотор уг системд нийтлэж, олон нийтэд зарласан. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусган Монгол улсын Сангийн ямаар батлуулж, захирамжийн дагуу эрх шилжүүлж ажилласан.
- Төрийн худалдан авалтын ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх, салбарын бодлого, зорилт ба цахим системийн онцлогийн талаар мэдээлэл хүргэх зорилгоор Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын Сангийн яамны Хууль Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран 2017.03.31 өдөр “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалт зохион байгуулж, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 19 мэргэжилтэнийг хамруулсан.

- Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, захирамж гаргасантай холбоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтын дагуу Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг www.tender.gov.mn, <http://tender.ub-procurement.mn/> -д ил тод, нээлттэй мэдээлэх, биелэлтийг тайлагнах талаар 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад зөвлөмж чиглэл хүргүүлсэн.
- Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон. Үүний хүрээнд 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.
- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран 2017 оны 12 сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.
- Тус газар нь Нийслэлийн Засаг даргаас эрх шилжин, Улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс шалгаруулалтыг зарлаж эхлүүлсэн 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим систем www.tender.gov.mn-ээр зохион байгуулж, тендертэй холбоотой бүх төрлийн баримт бичгийг /файлаар/ нийтэлж, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Төрийн нууцтай холбоотой болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь олон улсын журмаар зохион байгуулагдсан тул уг системээр тендерийг зарлаагүй.
- Улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Үүнээс сонгон худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендер зарлагдсан

152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний урилга, зар болон сонгон шалгаруулалтын дүн гарсан 152,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 327 төсөл, арга хэмжээтэй холбоотой шалгарсан, шалгараагүй талаарх мэдээллийг оролцогч тус бүрээр зарлан мэдээлээд байна.

б/ Худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Тайлан хугацаанд үнэлгээний хороо байгуулах тушаал 73, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 40, нийт 113 тушаал баталсан. Эдгээр үнэлгээний хороонд 2016 оны НИТХ-ын 48 дугаар тогтоолоор батлагдсан АЗ гэрчилгээтэй иргэн 35 иргэн олон нийтийн төлөөллөөр ажилласан. Үнэлгээний хороонд ажилласан олон нийтийн төлөөлөлд цагийн бүртгэлийг үндэслэн ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх хэмжээ буюу 3156 төгрөгийн урамшуулал хөлс олгож байна. Үүний дагуу 2017 онд үнэлгээний хорооны ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн нийт 54 удаа 2,414.202 төгрөгийн урамшуулал олгоод байна.
- Хууль, журмын дагуу худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн төлөөллөөр ажиллаж, хяналт тавих эрх бүхий АЗ гэрчилгээ эзэмшсэн нийслэлийн 50 иргэний мэдээллийг 2017 оны 06 сарын 22-ны өдрийн 01/874 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргаар дамжуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд өргөн барьсан.
- Тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийн төлөөллийг урьж, 2017 оны 09 сарын 05-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.
- “Тендерт хэрхэн амжилттай оролцох вэ?” сэдэвт сургалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Хамтын хөгжлийн мэргэшсэн институт” төрийн бус байгууллагатай хамтран 2017 оны 10 сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтад 42 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж, цахим систем ашиглалттай холбоотой заавар зөвлөмж, системийн шинэчлэлтийн талаар мөн Сангийн яаманд үүсч буй гомдол маргааны шалтгаан, тендерт оролцогчийн анхаарах зүйлсийн талаар бодит судалгаа, баримт бүхий мэдээлэл хүргэж ажилласан.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санаачлан 2017 оны 02 дугаар сарын 20-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатар худалдан авалт 2016” бизнес чуулга уулзалтын үеэр аж ахуй нэгжийн 46 төлөөлөл, “Иргэний оролцоотой эрх зүйн жил”-ийн хүрээнд Засгийн газраас зохион байгуулсан 2017 оны 05 сарын 15-ны өдрийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр иргэн, аж ахуйн нэгжийн 36 төлөөлөл, 2017 оны 10 сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Тендерт хэрхэн амжилттай оролцох” тухай сургалтын үеэр тендерт оролцогч аж ахуйн нэгж, компанийн 34 төлөөллөөс тус тус худалдан авах ажиллагааны чанар, үр дүнгийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан. Эдгээр судалгааны үр дүнг нэгтгэн, хууль, журмын зохицуулалт болон цахим тендерийн системийг боловсронгуй болгоход санал хүргүүлэх, нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх талаар 2017 оны 05 сарын 22-ны өдрийн үнэлгээний хорооны нарийн бичгүүдийн хурлаар авч хэлэлцэн, зөвлөмж, чиглэл өгч ажилласан.

БҮЛЭГ ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын хяналтад байгаа дараах тогтоол, шийдвэр, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, <http://lmonitoring.ub.gov.mn> программд улирал тутамд тайлагнаж ажилласан.

Хүснэгт 1. Тогтоол, захирамжийн хэрэгжилт

№	Баримт бичгийн нэр	Шийдвэрийн тоо	Нийт заалт	Хэрэгжилтийн хувь						Биелэлтийн хувь
				100%	90%	70%	50%	30%	10%	
1	Засгийн газрын тогтоол	3	3	2	1					99%
	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	3	2	1					95,8%
2	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр	1	1	1						100%
3	Нийслэлийн Засаг даргын захирамж /ХАА холбоотой/	34	278	257	2	6	11		2	96,7%
4	Нийслэлийн Засаг даргын захирамж /үйл ажиллагаатай/	10	12	11	1					100%
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	10	24	22	1	1				99,2%
6	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	20	49	49						100%
	Нийт	93	370	344	6	7	11		2	97,3%

2.1 Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт, үр дүн

- Бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотой Ёс зүйн хороог шинэчлэн А/127 дугаар тушаалаар 5 мэргэжилтэний бүрэлдэхүүнтэй байгуулж, хууль журмын дагуу үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.
- 2017.01.19-ний өдрийн А/06 тоот тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулсан.
- “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, ажлын байранд хориглох зүйл, Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа албан хаагчдад хориглох зүйлсийг нарийвчлан зааж 2017.02.20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан.
- Давхар ажил эрхлэлтийн тухай хууль, журмын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, албан хаагчдад мэдээлэл өгөх, нийтийн албанд томилогдож буй албан хаагчдыг хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил үүрэг гүйцэтгэж буй эсэхтэй танилцан, шийдвэрлэж ажилласан.
- Эрх бүхий албан тушаалтан шинэчлэгдсэн бүтцийн дагуу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах хуулийн үйлчлэлд хамаарах 9 албан

хаагчдад ХАСХОМ мэдүүлэх талаар сургалтыг 2017 оны 01-р сарын 19-ний өдөр зохион байгуулсан.

- Хуулийн дагуу 2017 онд нийт давхардсан тоогоор 14 албан хаагч шинэчлэн буюу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг цахимаар мэдүүлж, цахимаар мэдүүлсэн мэдүүлгээ баталгааны маягтаар баталгаажуулан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.02.15-ны өдрийн 04/640 дугаартай “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газраас батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож, ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг мэдүүлгийн системтэй уялдуулан үнэн зөв гаргаж 2017.02.23-ны өдөр хүргүүлсэн.

- Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын 4.2-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан албан хаагчдын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.01.12-ны өдрийн 04/160 дугаартай “ХАСХОМ-ийг баталгааны маягтаар бүртгэж авах тухай” албан бичгийн дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлт буюу уг тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан 3 төрлийн баталгааны маягтыг өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан.

- Үнэлгээний хорооны гишүүд 473 удаад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаж ажилласан ба уг мэдэгдлийг shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.

- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 10-р сарын 03-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад “Авлигын мөн чанар, шалтгаан хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчил, байгууллагын ил тод байдлыг хэрхэн хангах талаар сургалт зохион байгуулсан.

- 2017.11.29–ний өдөр АТГ-ын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 2017 оны 04-р сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт”, мөн хуулийн 16-р зүйл бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт сэдэвт сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан.

- Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт батлах тухай А/139 дугаар тушаалыг 2017.11.20 өдөр батлан байгууллагын нийт албан хаагчдаас “Нууцын баталгаа”-г гаргуулж ажилласан. Уг журмын 1 дүгээр хавсралтаар Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт, 2 дугаар хавсралтаар Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтныг зааж өгч ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018.01.15-ны дотор, 2017 оны ХАСХОМ-ын тайланг 2018.02.01-ний дотор НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.

- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалт гарган Сангийн яаманд бүртгүүлэх, дахин тендер шалгаруултад оролцуулахгүй байх арга хэмжээний хүрээнд тендерийн баримт бичгийг хуурамаар бүрдүүлж ирүүлсэн. Үүний дүнд “Хансуун зам” ХХК, “Пи Си Эф” ХХК, “Биндэгноров” ХХК, “Тас Хайрхан” ХХК-уудыг хар

жагсаалтад оруулахаар Сангийн яаманд 2017 оны 10 дугаар 13-ны өдрийн 02/1710 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2.2 Монгол улсын Засгийн газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолын биелэлт, үр дүн

“Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж, жил бүрийн худалдан авахаар батлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр сард багтаан үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх”

- Монгол улсын Засгийн газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолын дагуу

“2016 онд нийслэлийн хэмжээнд дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний судалгаа”-г /9,7 тэрбум төгрөгийн 12 нэр төрлийн 703 ширхэг бараа бүтээгдэхүүн/ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагуудаас нэгтгэн 2017.02.20 өдрийн 01/120 дугаар албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

- 2017 оны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Бараа худалдан авах тендерт 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах”-аар төлөвлөсний дагуу бараа худалдан авсан 216 төсөл, арга хэмжээний тендерийн урилга болон тендерийн баримт бичигт Засгийн газрын 336 дугаар тогтоолоор батлагдсан дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаар тусгасан. Үүний дүнд 9 багц ажилд 3,812,464,189 /гурван тэрбум найман зуун арван хоёр сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга нэг зуун наян ес/ төгрөгийн өртөг бүхий 95 нэр төрөл бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.

2.3 Монгол Улсын Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын биелэлт, үр дүн

Байгууллагын удирдлагыг хэрэгжүүлэхдээ дунд түвшний удирдагчийг идэвхижүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар хэлтэс, нэгжийн зохион байгуулалтыг хийсэн. Албан хаагчид харьяалан ажиллах хэлтсийн даргаас үүрэг чиглэл авч, ажил үүргийн биелэлтийг хангаж ажиллах ба хэлтсийн дарга нарт орлогч дарга, даргаас чиглэл заавар өгч, ажлын биелэлтийг хангуулах замаар удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний дүнд удирдах үйл ажиллагааны хурдыг сайжруулах нэгж албан хаагчийг богино хугацаанд үүрэгжүүлэх, дунд шатны удирдлагаас тухайн албан хаагчийн ажлын чанар, үр дүнг бодитоор үнэлэх, заавар чиглэл өгч сайжруулах, ажлын ачааллыг хуваарилах боломж, нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журмыг 2017 оны 12 сарын 05-ны өдрийн А/145 тушаалаар батлан, нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Үүний дүнд хэлтэс, нэгжүүдийн чиг үүргийн хэрэгжилт болон үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үр дүнг стандартын дагуу тайлагнах, үнэлж дүгнэх аргачлалыг тодорхойлж ажилласан. Мөн захирамжлалын баримт бичгийн програм <http://monitoring.ub.gov.mn>-д урлирал, хагас, бүтэн жилээр хугацаанд нь оруулж ажиллаж байна.

2.4 Монгол улсын Засгийн газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 01 дугаартай “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын хэрэгжилтийг биелэлт, үр дүн

- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу тус байгууллагаас авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017 оны 11 сарын 03-ны өдөр батлан, нийт албан хаагчдад танилцуулга хийж, биелэлтийг ханган ажиллаж байна.

- Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор 2017 оны 10 сард Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, А/127 дугаар тушаалаар батлан, хууль журмын дагуу үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.

- Ёс зүйн зүйн зөрчлийн болон албан үүргээ биелүүлэхдээ иргэд үйлчлүүлэгчтэй эелдэг бус харьцаж, ялгаварлан гадуурхсан, хүнд суртал гаргасан талаарх зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг <http://ub-procurement.mn/> цахим сайтад нээлттэй байршуулаад байна.

- “Байгууллагын ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн ёс зүйн хорооны талаарх 3 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх 2 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх 6 зүйл бүхий нэмэлт өөрчлөлтийг хийж батласан.

- Ёс зүйн хороо нь 2017.11.03-нд “Ёс зүй гэж юу вэ?, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, дүрмийн талаарх танилцуулах” сургалт, 2017.11.21-ний өдөр “Монгол улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгавар, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас баталсан төлөвлөгөө болон НХААГ-ын төлөвлөгөөг танилцуулах” мэдээлэл, 2017.11.29-ний өдөр “Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт, мөн хуулийн 16 дугаар зүйл “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт” сэдэвт сургалт, 2017.12.01-нд Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Гүндэгмаатай хамтран “Төрийн албан хаагчийн харилцааны болон биеэ авч явах соёл” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, төрийн албаны онцлог, үнэт зүйлс ба албан хаагчийн хувцаслалт, харилцааны онцлог, хариуцлага, яамлах ёс болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн талаарх хууль, дүрэм журмын талаар нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгч хамтран ажилласан.

- Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх ажлын хүрээнд ажилдаа хариуцлагагүй хандсан 2 албан хаагч, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага алдсан 2 албан хаагч болон нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан 5 албан хаагч нарт тус тус сануулах сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг авсан.

- “Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих тухай” журмыг шинэчлэн боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/131 тушаалаар батлуулсан. Уг ажлын хүрээнд 10 дугаар сарын ажлын цаг бүртгэл болон ажлын цаг ашиглалтын журмыг зөрчсөн 12 албан хаагчид анхааруулга өгсөн. Үүний дүнд 11 дүгээр сард албан хаагчдын ирц, ажлын цагийн нягтрал сайжирч анхааруулга авсан албан хаагчдын тоо 50%-иар буурсан бөгөөд журмыг дахин зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцохоор төлөвлөн ажиллаж байна.

- Хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих чиглэлээр Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар үр

дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих ажиллаж байгаа байгаа бөгөөд тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлээр 62,0 сая төгрөгийг хэмнэсэн байна. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө 18,0 сая төгрөгөөр батлагдсан ба тайлант хугацаанд тендерийн баримт бичгийн орлогоос 50,2 сая төгрөг олж орлогын төлөвлөгөөг 32,2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын биелэлтийг хангах 2017 оны 11 сарын 03-ны өдөр төлөвлөгөөний хэрэгжилтийг <http://monitoring.ub.gov.mn> цахим систем нийтлэн, 2017 оны 11 сарын 10-ны өдрийн 01/1810 тоот албан бичгээр холбогдох газарт хүргүүлээд байна.

- 2017.01.19-ний өдрийн А/06 тоот тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулсан.

- “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, ажлын байранд хориглох зүйл, Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа албан хаагчдад хориглох зүйлсийг нарийвчлан зааж 2017.02.20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан.

- Давхар ажил эрхлэлтийн тухай хууль, журмын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, албан хаагчдад мэдээлэл өгөх, нийтийн албанд томилогдож буй албан хаагчдыг хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил үүрэг гүйцэтгэж буй эсэхтэй танилцан, шийдвэрлэж ажилласан.

- Эрх бүхий албан тушаалтан шинэчлэгдсэн бүтцийн дагуу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах хуулийн үйлчлэлд хамаарах 9 албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэх талаар сургалтыг 2017 оны 01-р сарын 19-ний өдөр зохион байгуулсан.

- Хуулийн дагуу 2017 онд нийт давхардсан тоогоор 14 албан хаагч шинэчлэн буюу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг цахимаар мэдүүлж, цахимаар мэдүүлсэн мэдүүлгээ баталгааны маягтаар баталгаажуулан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.02.15-ны өдрийн 04/640 дугаартай “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газраас батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож, ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг мэдүүлгийн системтэй уялдуулан үнэн зөв гаргаж 2017.02.23-ны өдөр хүргүүлсэн.

- Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын 4.2-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан албан хаагчдын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.01.12-ны өдрийн 04/160 дугаартай “ХАСХОМ-ийг баталгааны маягтаар бүртгэж авах тухай” албан бичгийн дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлт буюу уг тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан 3 төрлийн баталгааны маягтыг өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан.

- Үнэлгээний хорооны гишүүд 473 удаад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаж ажилласан ба уг мэдэгдлийг “shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.

- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 10-р сарын 03-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад “Авлигын мөн чанар, шалтгаан хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчил, байгууллагын ил тод байдлыг хэрхэн хангах талаар сургалт зохион байгуулсан.
- 2017.11.29–ний өдөр АТГ-ын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 2017 оны 04-р сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт”, мөн хуулийн 16-р зүйл бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт сэдэвт сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан.
- Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт батлах тухай А/139 дугаар тушаалыг 2017.11.20 өдөр батлан байгууллагын нийт албан хаагчдаас “Нууцын баталгаа”-г гаргуулж ажилласан. Уг журмын 1 дүгээр хавсралтаар Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт, 2 дугаар хавсралтаар Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтныг зааж өгч ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018.01.15-ны дотор, 2017 оны ХАСХОМ-ын тайланг 2018.02.01-ний дотор НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.
- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалт гарган Сангийн яаманд бүртгүүлэх, дахин тендер шалгаруултад оролцуулахгүй байх арга хэмжээний хүрээнд тендерийн баримт бичгийг хуурамаар бүрдүүлж ирүүлсэн Үүний дүнд “Хансуун зам” ХХК, “Пи Си Эф” ХХК, “Биндэгноров” ХХК, “Тас Хайрхан” ХХК-уудыг хар жагсаалтад оруулахаар Сангийн яаманд 2017 оны 10 дугаар 13-ны өдрийн 02/1710 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчоос ирүүлсэн саналын бүрэн бүтэн байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 онд 326 ширхэг лацыг ашиглаад байна.
- Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг санамсаргүй байдлаар сонгох аргыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.5 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон “Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах хүрээнд 2017 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг богино хугацаанд сонгон шалгаруулж энэ онд багтаан угсралтын ажлыг хийлгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах” ажлын биелэлт, үр дүн

Нийслэлийн Засаг даргаас 2017 оны А/163, А/505, А/588 захирамжаар тус тус эрх шилжүүлсэн Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийт 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгдсөн бөгөөд 89.2 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд, гэрээ байгуулагдсан 9 төсөл, арга хэмжээ буюу 100 хувьтай, тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 1 төсөл, арга хэмжээ 70 хувьтай, тендерийн материал хүлээн авч байгаа 2 төсөл, арга хэмжээ буюу 50 хувьтай хэрэгжиж байна.

2.6 Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүн

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn- цахим системд бүртгэж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжийн дагуу эрх шилжүүлэлт, багцлалтыг хийж ажилласан. Мөн системд заасан маягтын дагуу төсвийн тодотгол, өөрчлөлт болон төсөл, арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа Монгол улсын Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөний өөрчлөлтийг батлуулж, нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалт худалдан авалтыг уг системээр дамжуулан зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай эхлүүлэх зорилгоор захиалагч 12 байгууллагад зураг төсөв, ажлын даалгавар ирүүлэх талаар 97 удаа албан бичгээр хандаж хамтран ажилласан.

2.7 Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт, үр дүн

Худалдан авах ажиллагаатай холбоотой захирамжийн тухайд 2017 оны 12 дугаар сарын 12-ны улс, нийслэл, гадаадын зээл тусламж, орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг тус газарт Нийслэлийн Засаг даргын 33 захирамж болон нийт 8 албан бичгээр 172,577.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 352 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа буюу 2,670.5 сая ам долларын 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Товчоор, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын дүн гарч гэрээ байгуулагдсан 333 төсөл, арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, захиалагч байгууллагад гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 2 төсөл, арга хэмжээ 90 хувийн биелэлттэй, тендерийн үнэлгээний шатанд шилжсэн 6 төсөл, арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, тендерт оролцогчоос материал хүлээн авч байгаа 11 төсөл, арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, тендер зарлахаар бэлтгэл хангаж буй 2 төсөл, арга хэмжээ 10 хувийн биелэлттэй нийт ажлын хэрэгжилт 96,7 хувь байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 14,640.4 сая төгрөгийн 63 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байгаагаас 14,230.6 сая төгрөгийн 61 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулсан, 409.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний тендерийн материал хүлээн авч байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт: 152,703.8 сая төгрөгийн 282 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байгаагаас 148,518.4 сая төгрөгийн 266 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа, 2,971.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендерийн үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 1,158.4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний тендерийн материал хүлээн авч, 56.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээнд тендерийн бэлтгэл хийгдэж байна.

Дэлхийн банкны санхүүжилт: 1,924,3.6 сая төгрөгийн 6 төсөл, арга зохион байгуулагдаж байгуулагдаж гэрээ байгуулагдсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилт: 3,309.4 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа ба тендерийн үнэлгээ хийгдэж байна.

БНХАУ-ын санхүүжилтээр: 2,670.5 сая ам долларын 2 төсөл, арга хэмжээний арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гэрээ байгуулсан.

Хүснэгт 3. НХААГ-т зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээ

	Ажлын тоо	Ажлын тоо /%/	Батлагдсан төсөвт өртөг	2017 онд санхүүжих
1	2	3	4	5
1 Гэрээ хийгдсэн	333	94,1%	167 244 745,23	89 455 955,71
2 Захиалагчид гэрээ хийх зөвлөмж хүргүүлсэн	2	0,6%	99 000,00	99 000,00
3 Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа	6	1,7%	6 280 381,19	5 612 123,39
4 Тендерийн материал хүлээн авч байгаа	11	3,1%	1 568 209,86	1 567 609,86
5 Зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй ажил	2	0,6%	56 000,00	56 000,00
6 НИЙТ	354	100,0%	175 248 336,28	96 790 688,96

Чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой захирамжийн тухайд Нийслэлийн Засаг даргаас 10 удаагийн захирамжаар нийт 12 ажил үйлчилгээг үүрэг болгосон. Үүнээс 11 захирамжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй, 1 захирамж 90 хувийн биелэлттэй хэрэгжиж байна.

2.8 Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүн

2017 онд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 10 удаагийн хуралдаанаас 24 ажил, үйлчилгээг үүрэг даалгаварт өгсөн ба биелэлт 99,2 хувьтай хэрэгжүүлж, цаг тухай бүрт тайлагнаж ажилласан.

2.9 Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар

2017 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 21 удаа хуралдаж, тус газарт 49 удаагийн үүрэг даалгавар өгсөн ба эдгээр үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлж, биелэлтийг цаг хугацааны хоцрогдолгүй www.ulaanbaatar.mn байршуулан тайлагнасан.

“Эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүн

- “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил болгон зарлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/01 захирамж батлагдсантай холбоотой 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах саналыг 2017 оны 01 сарын 05-ны өдрийн 03/11 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 05 дугаар сард зохион байгуулсан “Эрх зүйн шинэтгэлийн жил” сэдэвт нээлттэй өдөрлөгт оролцож, 2017 оны 05 сарын 13-ны өдөр “Худалдан авах ажиллагааны чанар ба тэгш өрсөлдөөн” сэдэвт хэлэлцүүлэг хийж, иргэдэд хуулийн зөвлөгөө өгч, худалдан авах ажиллагааны талаарх төрөөс баримталж буй бодлого, шинээр хэрэгжүүлж буй ажил, салбарын үйл ажиллагаа, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэх өгөх, мөн 2017 онд нийслэл хотод хэрэгжиж буй худалдан авалтын талаар олон нийт, тендер сонирхогч аж ахуйн нэгж, иргэдийг мэдээллээр хангах чиглэлээр ажилласан.

- Эрх зүйн шинэтгэлийн жилийн хүрээнд худалдан авах ажиллагаатай холбоотой гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран ажиллаж, 2017 оны 12 сарын 6-8-ны өдрүүдэд “Худалдан авах ажиллагааны хууль журам ба тендертэй холбоотой үүсч буй гэмт хэргийг ангилах нь” сэдэвт илтгэлийг тавьж, мэдээлэл хийсэн.

- Монгол улсын Сангийн яамны 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан. Үүнтэй холбоотой тус газрын Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтэс, Хууль, хяналтын хэлтсээс “Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын эрх, үүрэг”-ийг хуульчлах талаарх шаардлага, үндэслэлийг боловсруулж, 2017 оны 06 сарын 13-ны өдөр ажлын хэсэгт танилцуулсан.

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг Дүүргийн Худалдан авах ажиллагааны алба болон тус байгууллагын нийт 53 албан хаагчид болон тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тендерийн жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 02/1758 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлсэн.

- Эрх зүйн ажлын тайланг 2017.06.16-ны өдрийн 03/827 дугаартай албан бичиг, 2017.12.08-ны өдрийн 03/1925 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын ХЭЗХ-т тус тус хүргүүлсэн.

- Газрын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 5 гомдол, 49 хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Үүнээс тендер оролцогч аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол, саналыг судлаж, ил тод, нээлттэй байдлыг хуулийн хүрээнд дээшлүүлж худалдан авах ажиллагааны цахим систем, байгууллагын цахим хуудсыг мэдээллийг тогтмол шинэчлэх талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажилласан.

БҮЛЭГ ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт, байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл

Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах “Үр дүнгийн гэрээ”, байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэмжээнд 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 27 арга, хэмжээний календарчилсан загвар/-г боловсруулан 2017 оны 01 сарын 20 өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу хэлтэс, нэгжээс хэрэгжүүлэх ажил үүргийн төлөвлөгөөг 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдөрийн А/35 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Биелэлтийг 2017 оны 06 сарын 04-ний өдрийн 01/999 дугаарт албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст илтгэх хуудсаар хүргүүлж ажилласан.

3.1.1 Байгууллагын даргын чиг үүргийн хүрээнд:

1. *Батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах.*

- Хүний нөөцийн асуудлаар 93 удаа “Б” тушаал баталж, хэрэгжилтийг хангасан. Үүнд: тэтгэмж олгох 4, төрийн албанаас чөлөөлөх 14, төрийн албанаас чөлөөлж, томилох 13, ажлаас чөлөөлөх 6, ээлжийн амралт олгох 3, жирэмсний амралт олгох 4, албан тушаалд томилох 19, албан тушаалд шилжүүлэн томилох 2, сахилгын шийтгэл ногдуулах 6, албан тушаал хавсруулан гүйцэтгүүлэх 2, түр орлон гүйцэтгүүлэх 1, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох 1 /2 албан хаагч/, хүндэтгэл үзүүлэх 2, цалинтай чөлөө олгох 7, цалингүй чөлөө олгох 2, төрийн албанаас халах 1, урамшил олгох 2, хүүхдээ асрах 4 тушаал багтаж байна.

2. *Холбогдох хууль тогтоомжийн дагуу Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох.*

- Газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/49 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилсэн боловсруулж, 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаартай тушаалаар батлаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, журмын дагуу албан хаагчдын цалинг сард 2 удаа тогтсон хугацаанд, хоол унааны хөнгөлөлтийг сар бүр олгож ажилласан. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25% хүртэл хэмжээгээр олгохыг хөдөлмөрийн гэрээнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

3. *Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх.*

- Хүний нөөцийн асуудлаар 93 удаагийн “Б” тушаал, үнэлгээний хороог томилох чиглэлээр 115 удаагийн А тушаал, дотоод үйл ажиллагаа болон төрийн захиргааны байгууллагын стандартыг хангах чиглэлээр 31 удаагийн А тушаалыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг 31 тушаалд дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам боловсруулах, шинэчлэн батлах талаар 7 тушаал, хууль журмын дагуу, чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулсан 6 тушаал, хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 3 тушаал, сургалт, томилолтын талаар 4, бусад үйл ажилагаатай холбоотой 9 удаагийн тушаал багтаж байна. Дүрэм журмын хувьд, Архивын дүрэм батлах тухай А/83, Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм батлах тухай А/84, Хөдөлмөрийн дотоод журам А/28, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам А/64, Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам А/124, Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах журам А/124, Албан

хаагчийн ёс дүйн дүрэм А/124, Удирдлагын зөвлөлийн хуралдааны үйл ажиллагааны журам А/124, Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам А/145, Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих журам батлах тухай А/131 журмуудыг баталж, биелэлтийг ханган ажиллаж байна.

4. Орлогч дарга болон хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.

- 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Орлогч дарга, хэлтсийн дарга мөн төрийн захиргааны 27 албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, 2017 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг хууль, журмын дагуу дүгнэн, “А” үнэлгээ авсан төрийн захиргааны 15, төрийн үйлчилгээний 2 албан хаагчид үндсэн цалингийн 80%-иар, “В” үнэлгээ авсан төрийн захиргааны 2 албан хаагчид үндсэн цалингийн 60%-иар тус тус урамшуулал олгон ажилласан.

5. Байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, удирдах дээд байгууллага, албан тушаалтанд танилцуулах.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг эрчимжүүлэх талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид танилцуулж, 2017.06.05-ны өдрийн А/447 дугаар захирамжийг батлуулан, нийслэлийн хэрэгжилтийг хангахад хамтран ажилласан. Үүний дүнд 2017 оны 06 сарын 22 өдрийн дотор 14 төсөл, арга хэмжээний зураг, төсөв ажлын даалгаврыг захиалагч байгууллагаас ирүүлсэн ба худалдан авах ажиллагааг эрчимжүүлэн ажилласан.

6. Газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

- 2017 оны 01 сарын 19-ний өдрийн А/06 тоот тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, 2017 оны 03 сарын 03-ны өдрийн А/35 дугаар тушаалаар батлаж мөрдүүлсэн.

7. Сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

- Газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/49 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, Төрийн албаны хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон албан хаагчдын эрхэлж буй ажлын онцлог, хариуцсан чиг үүргийн дагуу Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилсэн боловсруулж, 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаартай тушаалаар батлаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

- “Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтын журам”-ыг шинэчлэн боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 04 өдрийн А/131 дугаартай тушаалаар батлуулан батлагдсан өдрөөс мөрдөн ажиллаж байна. Хөдөлмөрийн сахилга бат алдсан, дээрх журмыг зөрчсөн 19 албан хаагчид сахилга хариуцлагаа дээшлүүлэн ажиллах талаар сануулга өгч ажилласны үр дүнд ажлын цаг хоцрогдолгүй хөдөлмөрийн сахилга бат дээшилсэн.

- Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмж болон Монгол Улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн “сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм бусад хууль тогтоомжийн талаар нийт албан хаагчдад 7 удаагийн сургалтыг зохион байгуулж, төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан.

8. Ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах.

- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэл, зорилгыг 2017.02.24-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар баталж, биелэлтийг хангах ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 12 албан хаагчид Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 заалтын дагуу 8 албан хаагчид ур чадварын нэмэгдэл цалингийн урамшуулал, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын дагуу зэргийн нэмэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу 1 албан хаагчид мэргэшсэн зэргийн цолны нэмэгдэл тус тус олгоод байна.

- Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу өндөр настны тэтгэвэрт гарсан 2, шинээр хүүхэдтэй болсон 7, нийт албан хаагчдын хүүхдэд бэлэг олгох зэрэг нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгож ажилласан.

- Эрүүл, зөв дадал хэвшлийг дэмжих зорилгоор Монголын үйлдвэрчний хорооны дэргэдэх ХНХ дээд сургуулийн спорт заалыг түрээсийн гэрээгээр ашиглан, нийт албан хаагчдад боломж нөхцлийг бүрдүүлж ажилласан. Мөн урлаг соёл, спортын олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг 2017.02.02 өдрийн А/10 тушаалаар баталсан. Уг зөвлөлөөс 5 удаагийн спортын арга хэмжээг зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан. Мөн Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2017.02.22 өдөр Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

- Нийслэлийн хэмжээнд 2017 онд хэрэгжих худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлангах” журмын нэгдүгээр хавсралт "маягт-1"-ийн дагуу боловсруулан 2016 оны 12 сарын 16-ны өдрийн 01/4278 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлсэн.

- 2017 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар Нийслэлийн Засаг даргаас тус байгууллагад эрх шилжүүлсэний дагуу улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 97,7 хувийн хэрэгжилттэй зохион байгуулж ажилласан.

- Төрийн цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn-д 2017 оноос эхлэн Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улсын төсвийн 15,520.4 сая төгрөгийн 67, нийслэлийн төсвийн 395,776.2 сая төгрөгийн 661 төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн www.tender.gov.mn цахим системд төлөвлөх, Монгол улсын Сангийн яамаар батлуулах, Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн систем дэх эрх шилжүүлэлтийг хийх мөн Дүүргийн Засаг дарга нараас эрх шилжүүлсэн 24,373.8 сая төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолд үндэслэн цахим системд төлөвлөх, Төсвийн Ерөнхийлөн захирагчаас батлах ажлыг www.tender.gov.mn цахим системээр дамжуулан хийж гүйцэтгэж байна. Мөн системд заасан маягтын дагуу төсвийн тодотгол, өөрчлөлт болон төсөл, арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа Монгол улсын Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөний өөрчлөлтийг батлуулж, нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалт худалдан авалтыг уг системээр дамжуулан зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Үүнд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах

тухай” 6/11 дүгээр тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас баталсан “Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-г 2017.01.15 өдрийн дотор уг системд нийтлэж, олон нийтэд зарласан. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусган Монгол улсын Сангийн яамаар батлуулж, захирамжийн дагуу эрх шилжүүлж ажилласан.

3.1.2 Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зорилтын хүрээнд:

1. Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хуулийн дагуу зохион байгуулах;

Ил тод:

- “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас батласан маягт 1-ийн дагуу батлуулан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn болон “Өдрийн сонин”-ы 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №004/5570 дугаарт хуулийн хугацаанд багтаан нийтлэж, олон нийтэд мэдээлсэн.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоол, 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор тус тус батлагдсан худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд бүртгэн төлөвлөлт үүсгэх, Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжийн дагуу эрх шилжүүлэх үүргийг гүйцэтгэж тендерийг цахим системээр зохион байгуулах боломж нөхцлийг бүрдүүлж ажилласан.
- Тайлант хугацаанд 230 удаагийн тендерийн урилга, зарыг өдөр тутмын сонинд зарлан мэдээлсэн. Үүнд, эхний улиралд “Өдрийн сонин”-д 38, “УВ пост” сонинд 11 удаа тендерийн урилга, зар нийтлүүлсэн. 2017 оны 2 дугаар улирлаас өдөр тутмын сонинтой хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, “Засгийн газрын мэдээ” сонинд 52, “Улс төрийн тойм” сонинд 47, “Монголын мэдээ” сонинд 64, “Өнөөдөр” сонинд 18 удаагийн тендерийн урилга, зар нийтлээд байна.
- Тус газарт Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Үүнээс сонгон шалгаруулалтыг зарлаж эхлүүлсэн 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, урилга, тендерийн холбогдолтой баримт бичиг болон сонгон шалгаруулалтын үр дүнг нээлттэй, ил тод мэдээлж ажилласан. Төрийн нууцтай холбоотой болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь олон улсын журмаар зохион байгуулагдсан тул уг системээр тендерийг зарлаагүй.

Өрсөлдөх тэгш боломжтой:

- 2017 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар байдлаар улс, нийслэл, бусад эх үүсвэрийн санхүүжилтээр нийт 354 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжин ирсэн. Үүнээс 110 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 417 аж ахуйн нэгж, иргэн оролцсон. Үүнээс бараа нийлүүлэх 92 тендер шалгаруулалтад 235 аж ахуйн нэгж, ажил гүйцэтгэх 149 тендер шалгаруулалтад 654 аж ахуйн нэгж, зөвлөх үйлчилгээний 113 тендер шалгаруулалтад 375 аж ахуйн нэгж, иргэн оролцоод байна. Нийт 354 төсөл, арга хэмжээний 44,3 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 18,8 хувийг харьцуулалтын аргаар, тендер шалгаруулалтын онцгой журам хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар 0,57 хувийг, гэрээ шууд байгуулах аргаар 4,3 хувийг, зөвлөх үйлчилгээний аргаар 32,1 хувийг тус тус зохион байгуулж ажилласан.

Хэмнэлттэй, үр ашигтай:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-т заасны дагуу худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан 2017 онд 335 төсөл, арга хэмжээг Төрийн цахим худалдан авах ажиллагааны системээр дамжуулан зохион байгуулж, www.tender.gov.mn, ub-procurement.mn сайтуудад тендерийн баримт бичиг холбогдох мэдээллийг файл хэлбэрээр шууд татан авч үзэх боломжтой байдлаар байршуулсан. Үүгээрээ цаасны хэрэглээг бууруулж, урсгал зардлыг бууруулсан.
- Батлагдсан 167,090,571.43 төсөвт өртөг бүхий 332 төсөл, арга хэмжээнээс 99,355,482.05 төгрөгөөр гэрээ байгуулан 67,735,089.38 төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн.
- 2017 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаж худалдан авах ажиллагаа зуун хувь хэрэгжсэн 167,090,571.43 төсөвт өртөг бүхий 332 төсөл, арга хэмжээ байна. Тендерийн сонгон шалгаруулалтын дүнд эдгээр төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн гэрээг 99,355,482.05 төгрөгөөр байгуулсан ба 67,735,089.38 төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн.

Хариуцлагатай:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн “Тендерт оролцогчдод давуу эрх олгох тухай заалт”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 259 төсөл, арга хэмжээнд “Дотоодын давуу эрх тооцох”-оор тендер зарласнаас 151 төсөл, арга хэмжээнд Дотоодын давуу эрх тооцуулахыг тусгасан санал ирүүлсэн. Үүнээс шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж нотлох баримтыг бүрэн ирүүлсэн 10 саналыг дэмжиж, давуу эрх тооцоод байна.

2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн жилд хийх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэж тайлагнах;

Нийслэлийн хэмжээнд 2017 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлангах нэгдүгээр хавсралтын "маягт-1"-ийн дагуу боловсруулан 2016 оны 12 сарын 16-ны өдрийн 01/4278 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлсэн.

3. Тендер зарлахын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний төлөвлөлт хөрөнгө оруулалтын бусад ажлуудтай уялдаж байгаа эсэхийг хянах;

Тендерийн бэлтгэл ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, уялдаа холбоог ханган ажиллаж байгаа ба энэ онд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон бусад

байгууллагаас нийт 143 зураг төсөв, Нийслэлийн Авто зам хөгжлийн газар болон бусад байгууллагаас 74 зураг төсөв хүлээн авч, тендер зохион байгуулж ажилласан. Зам, барилгын ажлын 6 ажлын зураг төсөвтэй холбоотой зөрчлийг арилгуулахаар Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2017 оны 03 сарын 21-ний өдрийн 03/192 дугаар албан бичгээр хүргүүлсэн ба захиалагч байгууллагатай хамтран зөрчлийг арилгаж ажилласан. Мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай эхлүүлэх зорилгоор захиалагч 12 байгууллагад зураг төсөв, ажлын даалгавар ирүүлэх талаар 97 удаа албан бичгээр хандаж хамтран ажилласан.

4. Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг төсөв батлагдсан даруйд шуурхай зохион байгуулах;

Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарснаас үнэлгээний хороо байгуулах хүртэл дунджаар ажлын 2 өдөр, үнэлгээний хороо байгуулагдсан өдрөөс тендер зарлах хүртэл дунджаар ажлын 5 өдөр, тендер нээсэн өдрөөс захиалагчид гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх хүртэл дунджаар ажлын 41 өдөр, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтад дунджаар ажлын 28-57 өдрийг зарцуулж ажилласан байна. Үүнээс ажил удааширч буй гол шалтгаан нь захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаа, гомдол үүсч, дахин зарлах болсонтой холбоотой байна. Зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаатай холбоотой удааширсан ажлын хувьд авч үзвэл, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарснаас ажлын 37-89 өдрийн дараа захиалагч байгууллагаас зураг, төсөв ирүүлсэн 17 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал, Зайсангийн авто замаас “Зайсангийн толгойн урдуур Богд уулын арын авто замтай холбогдох авто зам 2.4 км автозам”-ын ажлын зураг, төсвийг захиалагч байгууллагаас ажлын 89 өдрийн дараа ирүүлсэн байна.

5. Төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулах “Үнэлгээний хороо байгуулах”, хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл болох иргэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулах, бүрэлдэхүүн мэргэшсэн байх шаардлагыг хангаж ажиллах;

Тус газраас хуулийн дагуу төрийн бус байгууллага, НИТХ-ын тогтоолоор батлагдсан АЗ гэрчилгээтэй иргэдийн төлөөлөлтэй зөвшилцсөнөөр үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилсон 113 удаагийн тушаал баталсан. Эдгээр үнэлгээний хороонд 2016 оны НИТХ-ын 48 дугаар тогтоолоор батлагдсан АЗ гэрчилгээтэй иргэн 35 иргэн олон нийтийн төлөөллөөр ажилласан.

6. Захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн баримт бичгийг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

Тендерийн баримт бичгийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга захиалагч байгууллагаас ирүүлсэн ажлын даалгавар, зураг, төсвийн дагуу боловсруулан ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, үнэлгээний хорооны дарга, орлогч дарга, газрын даргад тус тус хянуулсаны үндсэн дээр батлаж тамгалах ба баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор 326 ширхэг лац ашиглаж, бүртгэл хөтлөж байна.

7. Тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон байгууллагынхаа цахим хуудсанд тогтоосон хугацаанд байршуулж, тендер шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дүнг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлэх;

- “Бараа, ажил, үйлчилгээ 2017 онд худалдан авах ерөнхий төлөвлөгөө”-г “Өдрийн сонин”-ы 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №004/5570 дугаарт болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тус тус нийтлэж олон нийтэд зарлан мэдээлсэн.

- Тус газарт Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Үүнээс сонгон шалгаруулалтыг зарлаж эхлүүлсэн 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр зохион байгуулж, урилга, тендерийн холбогдолтой баримт бичиг болон сонгон шалгаруулалтын үр дүнг нээлттэй, ил тод мэдээлж ажилласан. Төрийн нууцтай холбоотой болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь олон улсын журмаар зохион байгуулагдсан тул уг системээр тендерийг зарлаагүй.

– 2017 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар Шилэн дансны www.shilendans.mn систем болон байгууллагын www.ub-procurement.mn цахим системд сонгон шалгаруулалтыг зарлаж эхлүүлсэн 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтын үр дүн буюу шалгарсан, шалгараагүй талаарх хуулийн үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж ажилласан.

8. Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэх;

Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг явуулахтай холбоотой хэлтсийн дарга, үнэлгээний хорооны дарга нарын зүгээс үнэлгээний хорооны нарийн бичгийн даргыг тухай бүр аргачлалаар хангаж, холбогдох хууль, журам, зааврын дагуу зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн даргын зүгээс 7 хоног тутамд шуурхай хурал хийж үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарыг заавар зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

9. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах;

Тендерийн баримт бичгийн байнга хадгалах-112, түр хадгалах-24 баримтаар архивын нэгж үүсгэсэн. Мөн хууль, журамд заасны дагуу 2016 онд цахим системээр зарлагдсан 51 тендертэй холбоотой оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг 51 ширхэг CD-нд буулган архивласан.

10. Тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг зохих маягтын дагуу бэлтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлэх;

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1148 дугаар захирамжийн дагуу “Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайлан”-г нэгтгэн хүргүүлэх ажлын хүрээнд:

“2016 оны жилийн эцсийн тайлан”-г 01/32 дугаар, 2017 оны 1-р сарын тайланг 01/83 дугаар, 2-р сарын тайланг 01/144 дугаар, 3-р сар буюу 1 дүгээр улирлын тайланг НХААГ-ийн 01/276 дугаар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 01/1348 дугаар, 4-р сарын тайланг 01/417 дугаар, 5-р сарын тайланг 01/719 дугаар, 6-р сар буюу эхний хагас жилийн тайланг 01/1028 дугаар, 07-р сарын тайланг 01/1254 дугаар, 08-р сарын тайланг 01/1506 дугаар, 09-р сарын тайланг 01/1656 дугаар, 10-р сарын тайланг 01/1794 дугаар, 11-р сарын тайланг 01/1911 албан бичгээр холбогдох дээд газарт буюу Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. 12-р сар буюу 2017 оны жилийн тайланг 2017.12.15-ны өдөр хүргүүлэхээр бэлтгэж байна.

11. Худалдан авах ажиллагааны арга, хэлбэрийг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцсэн стандарт, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээ авах;

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг олон улсын журмаар зохион байгуулж, холбогдох дүрэм журам, стандартыг судлан, сайн туршлагаас нэвтрүүлж ажилласан.

Худалдан авах ажиллагааг олон улсын журмаар зохион байгуулахад хамтран ажиллаж, “Орлогод нийцсэн орон сууц” төслийн нэгж, Азийн хөгжлийн банкны олон улсын зөвлөхүүдийн багийн сургалт, Улаанбаатар гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгжээс худалдан авах ажиллагааны олон улсын журмын талаар зохион байгуулсан 5 удаагийн сургалт, семинарт оролцож, туршлага судалж ажилласан.

12. Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулах;

Монгол улсын Сангийн яамны 2017.05.23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус Газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын албан хаагчид болон тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Уг хэлэлцүүлэг нь тус байгууллагын болон Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах мэргэжилтнүүдийг хамруулан 2017.09.05-ны өдөр, тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийг хамруулан 2017.09.06-ны өдөр тус тус зохион байгуулагдсан.

13. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар болон бусад захиалагч байгууллагуудтай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын даалгаврыг шуурхай бэлтгэх талаар тогтмол хамтран ажиллаж, уялдаа холбоог хангаж байна. Мөн худалдан авах ажиллагааны сарын мэдээг холбогдох журам болон түүний хавсралтаар батлагдсан маягтын дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүргийн Худалдан авах ажиллагааны албадаас сар бүрийн 05-ны дотор авч нэгтгэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж байна. Төсвийн тодотгол, нэмэлт өөрчлөлттэй холбоотой Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцын тайлан, мэдээг НИТХ-ын тогтоолын дагуу гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тус тус хүргүүлсэн.

14. Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, ажлын гүйцэтгэл, цаг үеийн асуудлаар шуурхай үүрэг, даалгавар өгч, түүний биелэлтийг хангуулж ажиллах;

2017 оны 02 сарын 23-ны өдөр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга нартай хийх уулзалтын удирдамжийг батлаж, 2017 оны 03 сарын 14-ний өдрийн 09-12 цагийн хооронд уулзалт

зохион байгуулж, зөвлөмж чиглэл өгч ажилласан. Уг уулзалт нь хууль болон журам, зааврын хэрэгжилтийг хангахад гарч буй зөрүүтэй асуудлыг хэлэлцэн бодлогын хувьд нэгдсэн ойлголтод хүрэх талаар санал солилцож, цаашид худалдан авах ажиллагааг ил тод, хурдан шуурхай, богино хугацаанд зохион байгуулах, төрийн байгууллага хоорондын уялдааг сайжруулах, салбарын албан хаагчдыг чадавхижуулахад чиглэсэн юм.

- Сангийн яамны Хууль Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран 2017.03.31 өдөр “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалт зохион байгуулж, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албаны 19 мэргэжилтэнд худалдан авах ажиллагааны хэтийн чиг хандлага, цахим системийн онцлог давуу талын тухай мэдээлэл өгч ажилласан.

- Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.

- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран 2017 оны 12 сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.

15. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албад, Сангийн яамнаас зөвшөөрөлтэй Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрх бүхий төрийн бус байгууллагуудтай хууль, журмын хүрээнд хамтран ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 11 дүгээр хавсралт

3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

рилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар	
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	1) Газрын 2017 оны сургалтын төлөвлөгөөг 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлуулан 14 сургалтыг зохион байгуулсан. Үүнд, худалдан авах ажиллагаатай холбоотой 2, хууль дүрмийн талаар 4, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн асуудлаар 4, хувь хүний хөгжлийн талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	1,460.000 төгрөг		
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 дээш	хувиас		Дээрх сургалтуудад албан хаагчдын 92% хамрагдсан.	
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 дээш	хувиас		Монгол Улсын Сангийн яамны хэрэгжүүлж буй “Төслийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” төслийн ажлын хэсгийн гишүүнээр Газрын дарга Э.Болормаа ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд 2017 оны 8 дугаар сарын 19-26ны өдрүүдэд Индонез, Филиппин улсуудад ажиллаж урьдчилан худалдан авалтыг хэрэгжүүлж буй туршлага судлах, суралцах зорилгоор оролцсон. Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 2 хэлтсийн дарга, 15 албан хаагч хамрагдаж, хууль журам болон төрийн байгууллагын стандартын талаарх мэдлэг мэдээллийг	

					дээшлүүлж ажилласан. Дээрх сургалтуудад албан хаагчдын 52% хамрагдсан.		
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 дээш	хувиас	Газрын нийт албан хаагчдын 96% нь мэргэшсэн боловсон хүчин, 91% нь 3 ба түүнээс дээш жил ажиллаж байна.		
Хэсгийн дундаж: 100							
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Нийслэлийн 378 жилийн ойг тохиолдуулан НЗДТГ-ын “Жуух” бичгээр 3, НИТХ-ын Хүндэт үнэмлэхээр 3 нийт 6 албан хаагчийг шагнаж урамшуулсан.		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	Тус газарт 2017 онд Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 т заасны дагуу нийт 8 албан хаагч буюу 5,295,128.0 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу төрийн үйлчилгээний 1 албан хаагчид мэргэшсэн зэргийн цолны нэмэгдэл олгоод байна. Мөн Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмын дагуу 12 албан хаагчид 3,505,281.0 төгрөгийн хугацааны нэмэгдлийг олгогдоод байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017оны 354 дугаар тогтоолын дагуу 13 албан хаагчид 8,121,038.0 төгрөгийн ангилал, зэрэглэлийн нэмэгдлийг олгоод байна.	13,771.447.0 т өгрөг	

4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлэхэд шаардлагатай эд, материалаар хангах, цэвэрлэгээ үйлчилгээний чанарт анхаарч Нийтлэг үйлчилгээний газартай нягт хамтран ажилласан. Өдөр бүр ажлын цаг эхлэхээс өмнө бүх өрөө тасалгааны эмх цэгц, ариун цэвэрт анхаарч цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэж ажилласан. Судалгаагаар сэтгэл ханамж 90 хувьтай байна.			
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	2017 онд 33 албан хаагчид хоолны зардал 2500, унааны зардал 500 төгрөгөөр тооцон, сар бүр олгосон.	Хоол, унааны зардал 23,109.000 төгрөг		
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран нийт 33 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хамруулан ажилласан.			
		Албан хаагчдын хамрагдал	100 хувь	98%			
Хэсгийн дундаж: 100							
Үнэлгээний дундаж хувь:100							

3.3 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн үнэлгээтэй холбоотой мэдээлэл

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 сарын 24-ний өдрийн 335 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журмыг 2017 оны 12 сарын 05-ны өдрийн А/145 тушаалаар батлан, нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Үүний дүнд хэлтэс, нэгжүүдийн чиг үүргийн хэрэгжилт болон үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үр дүнг тайлагнах, үнэлж дүгнэх аргачлалыг тодорхойлж, төрийн байгууллагын стандартыг бэхжүүлэн ажиллаж байна.

3.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

- 2017 оны 12 сарын 12-ны өдрийн байдлаар тус газарт 5 гомдол, 50 хүсэлт ирсэн ба эдгээрийг Нийслэлийн өргөдөл гомдлын нэгдсэн систем Smartcity.mn цахим хуудаст бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Үүнд хугацаандаа 54, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 өргөдөл, гомдол байгаа ба шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 7 цаг 40 минут байна.

Үүнээс иргэний хүсэлтээр хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын талаар 3 удаа мэдээлэл, тайлбар өгч ажилласан. Тухайлбал, 2017 оны 04 сард Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэн М.Энхбаярын хүсэлтээр “Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил”-ын явц болоод төсөв хөрөнгийн шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Мөн 2017 оны 03 сар, 05 дугаар сард Нийслэлийн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Орлогч дарга Б.Гүндсамбуу нар оролцож, нийслэлд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт ба зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулж, иргэдийн хүсэлтээр дүүрэг, хороодод хэрэгжиж буй зарим ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр Сүхбаатар дүүргийн гэр хороололд оршин суугч иргэдийг төлөөлж иргэн Н.Батбаяр “тус дүүргийн гэр хорооллын доторх гудамж, зам талбайн тохижилт, сул шороо болон гэрэлтүүлэгтэй холбоотой энэ онд хийгдэх ажлын талаар” мэдээлэл хүссэн. Газрын дарга Э.Болормаа Сүхбаатар дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ онд 5, 7, 10, 12, 15, 17, 18, 20 дугаар хороодод тохижилтын ажил хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.

3.5 “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д тухайн жилд гаргах тайлан мэдээний тухай мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс үүрэг чиглэл болгосны дагуу буюу Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу lmonitoring.ub.gov.mn мэдээллийн цахим санд тухайн жилд гаргасан тайлан мэдээллийг цаг тухай бүрт нь мэдээлж ажилласан.

БҮЛЭГ ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр
тогтоолоор батлагдсан журмын 11 дүгээр хавсралт

4.1 Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	2017 оны 09 сарын 13-ны өдөр А/124 дүгээр тушаалаар “Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг шинэчлэн баталж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго, зорилт, хүний нөөц, төсөв санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг нээлттэй, ил тод байршуулах талаар тодорхой зохицуулж, биелэлтийг хангаж ажиллаж байна.	100
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудас www.ub-procurement.mn болон мэдээллийн самбарт санал хүсэлт, гомдол хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар болон Удирдлагаас иргэдтэй хийх уулзалтын хуваарийг нээлттэй, ил тод байршуулж, тухай бүрт шинэчлэн ажиллаж байна.	100
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудас www.ub-procurement.mn болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд “2017 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай ерөнхий төлөвлөгөө, тендерийн урилга, баримт бичиг болон ажлын тоо хэмжээ, зураг төсөв бусад холбогдох материалыг файл хэлбэрээр татаж авч үзэх боломжтой байдлаар ил тод, нээлттэй мэдээлж байна. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт буюу АЗ гэрчилгээ олгох сургалтын хуваарь, Үнэлгээний хорооны	100

		бүрэлдэхүүнд ажиллах сонирхолтой иргэн, олон нийтийн төлөөлөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон холбогдох хууль, журмын талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулсан.	
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх;	Үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагаатай холбогдолтой хүчин төгөлдөр мөрдөж буй хууль 15, журам заавар 15, жишиг бичиг баримт 10, худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийг тухай бүрт цахим хуудас www.ub-procurement.mn -д тусгай цэс үүсгэн байршуулж, мэдээллийн самбарт тодорхой агуулгаар сонгон авч нээлттэй мэдээлж байна.	100
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үүрэг чиглэл болгосны дагуу бодлогын баримт бичиг, захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөлд санал хүргүүлж ажилласан.	-
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Тендерийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, хариуцлагатай, хэмнэлттэй зарчмаар зохион байгуулахын тулд Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулан ажилласан. 2017 оны 11 сарын 01-ний өдрөөс ажлын 5 хоногийн хугацаанд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт,	100

		<p>дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Мөн 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулсан. Уг сургалтаар худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангаж ажилласан.</p>	
7.	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p>	<p>Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээ байхгүй байна.</p>	-
8.	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа</p>	<p>Тус байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.</p>	-

	ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудас http://ub-procurement.mn/ болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл, тендерийн нээлтийн мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэлийг тухай бүрд нээлтэй, ил тодоор мэдээлж ажилласан. Мөн худалдан авах ажиллагааны явцын сарын мэдээг товч хэлбэрээр нийтлэж байна.	100
Хэсгийн дундаж хувь:100			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Тус байгууллага нь 35 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй батлагдсан бөгөөд 2017 онд түр орлон гүйцэтгүүлэх 1, албан тушаалд томилох 19 удаагийн тушаал баталж ажлын байрны хэвийн үйл ажиллагааг хангасан. Эдгээртэй холбоотой сул орон тооны мэдээллийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулж ажилласан.	100
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн ёс зүйн зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор Ёс зүйн зүйн дүрэм болон ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулан шинэчилсэн.	100
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэл, зорилгыг 2017 оны 02 сарын 24-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар баталж, байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст нээлттэй байршуулж ажилласан.	100
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч	Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй	100

	хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	үйл ажиллагааны талаар байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст 5 удаагийн мэдээ, мэдээллийг нийтлэж, байршуулсан.	
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Монгол Улсын Төрийн албаны тухай зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулсан.	100
		Хэсгийн дундаж хувь:100	
		Хэрэгжилтийн дундаж хувь:100	

ТАВ. БУСАД ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

4.2 Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл;

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны 9 албанд 2017 оны 06 сарын 16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласан.
- Нийслэлд 2017 онд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг эрчимжүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 сарын 15-ны өдрийн А/447 дугаар захирамжийг батлуулан, хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай эхлүүлэх зорилгоор захиалагч 12 байгууллагад зураг төсөв, ажлын даалгавар ирүүлэх талаар 97 удаа албан бичгээр хандаж хамтран ажилласан.
- Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017 оны 10 сарын 16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017 оны 11 сарын 01-07-ны өдрийн хооронд худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.
- 2017 оны 10 сарын 26-ны өдөр “Тендерт хэрхэн амжилттай оролцох вэ?” сэдэвт сургалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Хамтын хөгжлийн мэргэшсэн институт” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад 42 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж, цахим систем ашиглалттай холбоотой заавар зөвлөмж, системийн шинэчлэлтийн талаар мөн Сангийн яаманд үүсч буй гомдол маргааны

шалтгаан, тендерт оролцогчийн анхаарах зүйлсийн талаар бодит судалгаа, баримт бүхий мэдээлэл хүргэж ажилласан.

- 2017 оны 11 сарын 23-ны өдрийн 147 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг төлөвлөж хөтөлбөр баталсан. Уг хөтөлбөрийн дагуу 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг сургалтанд Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.

4.3 Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл;

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 сарын 24-ний өдрийн 335 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журмыг 2017 оны 12 сарын 05-ны өдрийн А/145 тушаалаар батлан, нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Үүний дүнд хэлтэс, нэгжүүдийн чиг үүргийн хэрэгжилт болон үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үр дүнг тайлагнах, үнэлж дүгнэх аргачлалыг тодорхойлж, төрийн байгууллагын стандартыг бэхжүүлэн ажиллаж байна.

4.4 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

- Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 3 удаа уулзалтанд оролцож, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын талаар мэдээлэл, тайлбар өгсөн. Тухайлбал, 2017 оны 04 сард Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэн М.Энхбаярын хүсэлтээр “Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил”-ын явц болоод төсөв хөрөнгийн шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Мөн 2017 оны 03 сар, 05 дугаар сард Нийслэлийн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Орлогч дарга Б.Гүндсамбуу нар оролцож, нийслэлд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт ба зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулж, иргэдийн хүсэлтээр дүүрэг, хороодод хэрэгжиж буй зарим ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр Сүхбаатар дүүргийн гэр хороололд оршин суугч иргэдийг төлөөлж иргэн Н.Батбаяр “тус дүүргийн гэр хорооллын доторх гудамж, зам талбайн тохижилт, сул шороо болон гэрэлтүүлэгтэй холбоотой энэ онд хийгдэх ажлын талаар” мэдээлэл хүссэн. Газрын дарга Э.Болормаа Сүхбаатар дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ онд 5, 7, 10, 12, 15, 17, 18, 20 дугаар хороодод тохижилтын ажил хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.

4.5 Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт;

- Сангийн сайдын 2013 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах тухай журам” нь 2017 оны 12 сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан. Үүнтэй холбоотой худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг уг журмын хавсралтаар батлагдсан Маягт 1-ийн дагуу боловсруулж батлах, Маягт 2, 3, 4, 5, 6, 7, 8-ийн дагуу тайлагнах асуудлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас чиглэл, зөвлөмж авах шаардлага үүсээд байна.

ТАНИЛЦСАН:
НХААГ-ИЙН ДАРГА



Э.БОЛОРМАА

БОЛОВСРУУЛСАН:
НХААГ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Д.Жаргалмаа

Д.ЖАРГАЛМАА